

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 310 дугаартай албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Налайх дүүргийн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг хавсралтаар баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Налайхын дулааны станц” ТӨХК (Ц.Энхтүвшин)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 668 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

### **НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно. Үүнд:

<b>№</b>	<b>Ангилал</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тариф</b>
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м <sup>3</sup>	1,100
		Төг/Гж	33,041
2	Төсвийн байгууллагын халаалт	Төг/м <sup>3</sup>	1,651
		Төг/Гж	33,041
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	6,930
		Төг/м <sup>3</sup>	6,912

2. Ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

<b>№</b>	<b>Ангилал</b>		<b>Хэмжих нэгж</b>	<b>Тариф</b>	
1	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "О"-ын өрөөний халаалт хамаарна)		Төг/м <sup>2</sup>	800	
2	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	Төг/хүн	3,680
			Халаалтын бус улиралд	Төг/хүн	5,152
		Усны зарцуулалтаар		Төг/м <sup>3</sup>	6,400
<b>3</b>	<b>Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф</b>				
3.1	40 м <sup>2</sup> хүртэл талбайтай айл өрх		Төг/сар	3,840	
3.2	40 м <sup>2</sup> -аас 80 м <sup>2</sup> талбайтай айл өрх		Төг/сар	6,400	
3.3	80 м <sup>2</sup> -аас дээш талбайтай айл өрх		Төг/сар	12,800	